


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 06 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-26 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 8 аймагт **1327** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1327 тохиолдлын 94% /1248/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /78/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /9/, Сэлэнгэ /6/, Төв/16/, Дорноговь /2/, Баянхонгор /1/) бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **367** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **26**ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.06.22 – 06.28)


2025 оны эпидемиологийн 26 дугаар долоо хоногт 2 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 88.9 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 72.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

**ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ**

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-26 дугаар долоо хоногт нийт 669** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


386Эмнэлгийн
тусламж авч буцсан**283**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
45%Эмэгтэй
55%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 26 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **23** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 32.4 хувиар буурсан, сүүлийн 5 жилийн дунджаас 74.24 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 26 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	5	5	10
2	Эмийн хордлого	10	3	13
Нийт		15	8	23

Тухайн долоо хоногт химийн бодисын хордлогод **санаатайгаар** өртсөн тохиолдлууд зонхилж байгаа бөгөөд шалтгаанаар нь авч үзвэл 11-56 насны хүмүүс байгаа бөгөөд олон тооны эм хольж уусан байна.

-o0o-